



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Чанарын удирдлагын тогтолцооны  
бодлого, зорилт батлах тухай



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн Засаг даргын “ Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны А/500 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх үйл ажиллагааг хангах зорилгоор Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын чанарын удирдлагын тогтолцооны чанарын бодлого, зорилтыг хавсралтаар баталсугай.

2. Чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Г.Галбадрах)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Золбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.Д.У Л.ДЭЛГЭР



Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын  
даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны  
өдрийн 119 дугаар тушаалын хавсралт

## Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын чанарын бодлого

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж, хуулийн хүрээнд, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүү нягтлан бодох бүртгэл, эрүүл ахуй чанарын шаардлагад нийцсэн зоогийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн стандартын шаардлага хангасан цэвэрлэгээ үйлчилгээ, инженерийн байгууламжийн найдвартай эрсдэл гэмтэлгүй хэвийн ажиллагааг хангах, төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэн ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулна.

### Чанарын бодлогын зорилтууд

1. Чанарын менежментийн тогтолцооны стандартын анхдагч болон магадлан баталгаажуулалтын гэрчилгээг авсан байна.
2. Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг хэрэглэгчийн санал гомдолгүй үзүүлнэ.
3. Хангарди зоогийн газрын кофе шопын үйлчилгээг бүрэн ашиглалтад оруулна.
4. Үйлчилгээний хэсгийн ажилтнуудын нөөцийг нэмэгдүүлж, ачааллыг 10 хувиар бууруулна.
5. ХАБЭА-н сургалт, зааварчилгааны тоог нэмэгдүүлж, байруудад хэрэглэх үйл ажиллагааны зааварт аюулгүй ажиллах зааварчилгааг тусгана.
6. Хүний нөөцийн бодлогыг сайжруулах зорилгоор дотоод сургалт хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
7. Төрийн албан хаагчдийг мэдээ мэдээллээр хангаж харилцаа холбоо үүсгэж байгаа "Ер" нэгдсэн системийг газрын үйл ажиллагаатай уялдуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ.
8. Байгууллагуудын ажлын бүтээмж, үр дүнг дээшлүүлэх зорилгоор холбогдох журмыг шинэчлэх, дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тоог нэмэгдүүлнэ.
9. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг бодитой болгож, гарсан зөрчил дутагдлыг шуурхай арилгаж ажиллана

# НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ЯВУУЛСАН

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Тайлангийн дугаар:2023/01

**Шалгуур баримт бичиг:** Дотоод аудитын үед хийсэн ажиглалт, Аудитын шалгах хуудас, Ярилцлага, ISO9001:2016 стандартын 4.1, 4.2, 5.2, 6.2, 7.2, 9.1.2 шалгуурын дагуу хийсэн ажлын баримт бичиг

**Дотоод аудит явуулсан огноо:** 2023.06.13

**Дотоод аудит хийсэн ажилтны нэр, албан тушаал:**

М.Эрдэнэчимэг Архив, Худалдан авах ажиллагаа гэрээ хариуцсан ажилтан

Ю.Хүслэн Хууль эрх зүй, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан

А.Номинзул Хүний нөөц, сургалт хариуцсан ажилтан

Б.Доржбалжир Халаалт, агаар сэлгэлтийн ажилтан

Б.Анхтуяа Байр хариуцсан менежер

**Дотоод аудит хийлгүүлсэн нэгжийн нэр:** Захиргаа төлөвлөлт санхүүгийн хэлтэс,

### ТАЙЛАН

1. Нийт 6 шалгуураар дотоод аудитыг хийсэн






2. Аудитын явцад ажиглагдсан сайн талууд:

- Байгууллагын гадаад орчны шинжилгээ, дотоод орчны шинжилгээ хийгдсэн.
- Сонирхогч тал тэдний хүлээлт, шаардлагыг тодорхойлсон.
- Чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилтуудыг тодорхойлж Газрын даргын 2023 оны А/19 тушаалаар батлуулсан.
- Чанарын бодлого зорилтуудаа албан хаагчид компьютерын дэлгэцэд байршуулсан.
- Чанарын бодлого зорилтуудаа ажилтан албан хаагчдын мэдээллийн самбарт байршуулсан.
- Чанарын удирдлагын тогтолцооны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Газрын даргын 2023 оны А/23 тушаалаар батлуулсан.
- Ур чадварын матриц, Ур чадварын үнэлгээ хийгдсэн.
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг шинэчилсэн.

3. Аудитын явцад үл тохирол илрээгүй.

4. Сайжруулах шаардлагатай дараах Чанарын бодлого зорилтоо мэдээлэх асуудлыг зөвлөмжийн хамт гаргав.

5. Дотоод аудиторовын дүгнэлт: Аудит хийхэд үл тохирол илрээгүй ба Байгууллагын удирдлагууд нийт албан хаагчиддаа Чанарын бодлого, зорилтоо танилцуулах хурал хийж танилцсан албан хаагчдын гарын үсэг зуруулж баталгаажуулах шаардлагатай.

Тайлан бичсэн:	Ахлагч		(М.Эрдэнэчимэг)
	Гишүүн		(Ю.Хүслэн)
	Гишүүн		(Б.Анхтуяа)
	Гишүүн		(Б.Доржбалжир)
	Гишүүн		(А.Номинзул)



Огноо: 2023.06.13

Энэхүү тайлантай уншиж танилцсан:

Дотоод хяналт, шинжилгээ

үнэлгээний ажилтан

Газрын дарга

(Т.Азжаргал)

(Л.Дэлгэр)